

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан

2017 ОНД ТОХИОСОН СҮХБААТАР, ЖАВХЛАНТ, ХУШААТ СУМДЫН ОЙН ХАНДИВЫН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН

*Ойн хандив, тусламжийн орлогоос Сүхбаатар сум 3,571.0 мянган төгрөг,
Жавхлант сум 1,400.0 мянган төгрөг зэрэг нийт 4,971.0 мянган
төгрөгийг төлөвлөгдөөгүй ажил гүйцэтгэх, бусдад хандив өгөх зэргээр
зориулалт бусаар зарцуулсан байна.*

Тайланг бэлтгэсэн:

**Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын
газар**

Тэргүүлэх аудитор:
Ч.Энхтуяа

Аудитын менежер:
Б.Батмөнх

Аудитор:
Ц.Уртнасан
А.Дашбат

2018 оны 06 сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70362442 дугаарын
утас,
selenge@audit.gov.mn
хаягаар харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн Сүхбаатар
сум, аймгийн ЗДТГ-ын
байрны
өргөтгөлд

Агуулга

Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

Аудитын дүн :

1. Сумдын ойн болон хандив тусламжийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, бүрдүүлсэн үү ?

1.1 Ойн арга хэмжээ болон хандив тусламжийн орлогыг хууль журмын дагуу зохион байгуулж, бүрдүүлсэн үү?

1.2 Хандив тусламжийн орлогыг төлөвлөсний дагуу бүрэн бүрдүүлсэн үү?

1.3 Хандив тусламжийн мөнгөн болон хөрөнгийн орлогыг бүртгэл тайланд тусгасан уу?

2. Ойн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн гүйцэтгэж, хандив тусламжийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан уу?

2.1 Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн үү?

2.2 Хандив тусламжийн хөрөнгийг хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулсан уу?

2.3 Хандиваар бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгаж, гүйцэтгэлийг нийтэд тайлагнасан уу?

Илрүүлсэн зөрчил

Тайлангийн төслийн саналд өгсөн тайлбар

Дүгнэлт

Зөвлөмж

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ТББ	Төрийн бус байгууллага
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн Аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт:

2017 онд тохиосон Сүхбаатар сум үүсэн байгуулагдсаны 80 жил, Жавхлант сумын 40 жил, Хушаат сумын 30 жилийн ойн арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсээс өгсөн хандивын бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж өгөх, дүнг албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршлоо. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- *Сумдын ойн болон хандив тусламжийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, бүрдүүлсэн үү?*
- *Ойн хүрээнд төлөвлөсөн арга хэмжээг бүрэн гүйцэтгэж, хандив тусламжийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнасан уу?*

Хамрах хүрээ:

Аудитаар Сүхбаатар, Жавхлант, Хушаат сумдын ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалтыг сум орон нутгийн эрх бүхий байгууллагууд, ойн хандивыг зохион байгуулах чиглэлээр байгуулагдсан төрийн бус байгууллагуудын хүрээнд шалгахар Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны 05 сарын 17-ны өдрийн 57, 58, 59 дугаар бүхий албан бичгүүдээр дээрх сумдын Засаг дарга нарт мэдэгдсэний дагуу Сүхбаатар, Жавхлант сумд холбогдох баримт материалыг ирүүлэн аудитад хамрагдсан бол Хушаат сумын холбогдох баримт материалыг аудитын хугацаанд ирүүлээгүй учир аудитад хамрагдаагүй болно.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” төрийн бус байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах, худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны санхүүгийн тайлан, мэдээ, шаардлагатай бусад баримт, материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Төсвийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь

мөнхжүүлэх журам”, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 42 дугаар тогтоол, 2017 оны 18 дугаар тогтоол, Сүхбаатар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03, 13, 13А дугаар тогтоолууд, Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 13 дугаар тогтоол болон дээрх хууль, журмыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан бусад хууль, эрхийн актуудыг шалгуур болгон ашиглав.

Үндсэн мэдээлэл:

Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3.3 дахь заалт, Сэлэнгэ аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2015 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймагт сум, байгууллагын хэмжээнд тэгш ой тэмдэглэхэд зөвшөөрөл олгох журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 18 дугаар тогтоол, Сүхбаатар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор Сүхбаатар сум байгуулагдсаны 80 жилийн ойг, Жавхлант сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар тогтоолоор Жавхлант сум байгуулагдсаны 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тус шийдвэрлэсэн байна.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Ц.Уртнасан, А.Дашбат нар 2018 оны 5 дугаар сарын 28 -наас 6 дугаар сарын 29-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ДҮН

1. Сүхбаатар, Жавхлант сумд нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандивласан нийт 251,627.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг бүртгэл тайланд огт тусгаагүй байна.

1.1 Сүхбаатар сумын ойг тэмдэглэх ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, ажлын төлөвлөгөө, санхүүгийн төсөв зэрэг нь холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажаагүй бол Жавхлант сум нь холбогдох хууль, журмыг зөрчиж ойн арга хэмжээг зохион байгуулсан байна.

Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах дурсгалыг нь мөнхжүүлэх журам”-ын 3.3 дахь “ Орон нутгийн байгууллагын 50 болон түүнээс дээшхи 10 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэх асуудлыг аймаг, нийслэлийн ИТХ шийдвэрлэнэ “ гэсэн заалт болон Сүхбаатар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар тогтоолоор уламжилсан хүсэлтийг үндэслэн аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 18 дугаар тогтоолоор Сүхбаатар сум байгуулагдсаны 80 жилийн ойг 2017 оны 07 дугаар сард тэмдэглэхийг зөвшөөрсөн байна.

Аймгийн ИТХ-ын дээрх тогтоолын дагуу Сүхбаатар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр тогтоолоор Сүхбаатар сум байгуулагдсаны 80 жилийн ойг 2017 оны 07 дугаар сарын 28,29,30- ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэхийг сумын Засаг дарга Т.Гантулгад даалгасан байна.

Мөн сумын ИТХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор ойд бэлтгэх, ойн баярыг зохион байгуулах ажлын хэсгийг 14 хүний бүрэлдэхүүнтэй, 13А тогтоолоор, сум орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөө төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлтэй “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” төрийн бус байгууллагыг дарга, нягтлан бодогч гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулсан байна.

Тус ТББ нь 2017 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр улсын бүртгэлд бүртгүүлж, 1371001111 дугаартай гэрчилгээ авсан байна.

Сүхбаатар сум байгуулагдсаны 80 жилийн ойд бэлтгэх, ойн баярыг зохион байгуулах ажлын хэсгийн 2017 оны 04 сарын 03-ны өдрийн хуралдаанд сумын Засаг даргын орлогч М.Тэмүүлэн ойд бэлтгэх арга хэмжээний төлөвлөгөөг танилцуулсан бол “ Төрийн ёслол хүндэтгэл, зохион байгуулалтын асуудал” хариуцсан салбар хорооны 2017 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар үйл ажиллагаанд зарцуулагдах нэгдсэн төсвийг хэлэлцсэн байна.

Хэдийгээр ойд бэлтгэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан, нэгдсэн төсвийг хүснэгтээр хийж, хуралд танилцуулсан гэх боловч ажлын хэсгийн гишүүдийн хурлын тэмдэглэл, олонхийн санал болон холбогдох албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулаагүй зэрэг нь дээрх бичиг баримтуудыг хүчин төгөлдөр бус гэж үзэхэд хүргэж байгаа бөгөөд өөрөөр хэлбэл хурлын тэмдэглэл, ажлын төлөвлөгөө, санхүүгийн төсөв зэрэг нь албан бичиг баримт боловсруулах стандарт, журам, зааврын дагуу хийгдэж, баталгаажуулаагүй байна.

Харин Жавхлант сум байгуулагдсаны **40 жилийн** ой 2017 онд тохиож байгаа учир Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 3.3 дахь “ *Орон нутгийн байгууллагын 50 болон түүнээс дээшхи 10 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэх асуудлыг аймаг, нийслэлийн ИТХ шийдвэрлэнэ* ” гэсэн заалтын дагуу аймгийн ИТХ-аас 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай ямар нэгэн шийдвэр гаргаагүй байхад сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар тогтоолоор Жавхлант сум байгуулагдсаны 40 жилийн ойг тэмдэглэхээр тогтоосон нь дээрх тогтоолыг зөрчсөн байна.

Холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэр гараагүй байхад “Сумын хөгжил, иргэдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хүүхэд залуучуудыг дэмжих чиглэл” бүхий “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ -ыг байгуулан, 2017 оны 02 дугаар сарын 23-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж, 1371001109 дугаар бүхий улсын бүртгэлийн гэрчилгээ авсан байна.

Мөн “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ -ын даргаар сумын Засаг даргын орлогч Ж.Хүрэлбаатар ажиллаж, ойн арга хэмжээний хүрээнд хандив, тусламжаар

төвлөрсөн хөрөнгийг зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх ““ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдал” гэж тухайн нийтийн албан тушаалтан гишүүнчлэлд нь хамаардаг холбоо, сан, хамтын шийдвэр гаргадаг байгууллага, тэдгээрийн гишүүд,... гэх зэрэг олон нийтийн зүгээс ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгохуйц этгээдтэй холбоотой асуудлаар үйл ажиллагаа явуулахыг.”, 27 дугаар зүйлийн 27.2 дахь “Албан тушаалтан өөрийн үйл ажиллагааны шударга, төвийг сахисан байдалдаа ёс зүйн шалтгаанаар эргэлзээ төрвөл албан үүргээ гүйцэтгэхээс, эсхүл давхар ажил, албан тушаал эрхлэхээс татгалзах үүрэгтэй.”, 18 дугаар зүйлийн 18.1 дэх “Албан тушаалтан энэ хуулиар зөвшөөрснөөс өөр ажил, албан тушаал давхар эрхлэхийг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор сумын 40 жилийн ойг зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөө, төсвийг батлахдаа Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-н "В" дэх заалтыг үндэслэсэн боловч энэхүү заалт нь 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болсон байна.

Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор сум байгуулагдсаны 40 жилийн ойд бэлтгэх, ойн баяр, наадам зохион байгуулах комиссыг 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, сумын ИТХ ойн арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг баталсан байна.

1.2 Ойн арга хэмжээний хандив, тусламжийн орлогын төлөвлөгөө Сүхбаатар сумын хувьд 138,0 хувийн, Жавхлант сумын хувьд 87.4 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Сүхбаатар сумын 80 жилийн ойд бэлтгэх, ойн баярыг зохион байгуулах ажлын хэсгийн 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ –ийн дарга М.Суурьбат ойн арга хэмжээнд зарцуулагдах анхны төсвийг 369,356.0 мянган төгрөг байхаар танилцуулсан бол 2 дахь төсвийг 402,724.7 мянган төгрөгөөр төлөвлөж, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг хандив, тусламж өгөхийг уриалан Хаан банк, Төрийн банк, Голомт банкинд төвлөрүүлэхээр харилцах данс нээсэн байна.

Гүйцэтгэлээр ААНБ, иргэдээс нийт 370,357.8 мянган төгрөгийн мөнгөн, 185,380.0 мянган төгрөгийн биет зэрэг нийт **555,737.8** мянган төгрөгийн хандив, тусламж төвлөрүүлсэн нь төлөвлөсөн хэмжээнээс 153,013,1 мянган төгрөгөөр илүү буюу 138,0 хувийн биелэлттэй байна.

Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 13 дугаар тогтоолоор сумын 40 жилийн ойн хандивыг төвлөрүүлэн зарцуулах төсвийг нийт 230,088.6 мянган төгрөгөөр төлөвлөж, баталсан боловч гүйцэтгэлээр 201,054.1 мянган төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөсөн хэмжээнээс 29,034.5 мянган төгрөгөөр бага буюу 87.4 хувийн биелэлттэй байна. Сумдын хандив, тусламжийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 1, мян.төг/

№	Сумын нэр	Батлагдсан төсөв	Төвлөрүүлсэн дүн			Зөрүү	Биелэлтийн хувь
			Мөнгөн	Биет	Нийт		
1	Сүхбаатар	402,724.7	370,357.8	185,380.0	555,737.8	153,013.1	138.0
2	Жавхлант	230,088.6	134,806.6	66,247.5	201,054.1	-29,034.5	87.4
	Нийт дүн	632,813.3	505,164.4	251,627.5	756,791.9	123,978.6	119.6

Сүхбаатар сумын 80 жилийн ойд 169 ААНБ, 150 иргэн, Жавхлант сумын 40 жилийн ойд 11 ААНБ, 344 иргэн мөнгөн болон хөрөнгийн хандив өгсөн ба Сүхбаатар суманд 6 ААНБ, 1 иргэн нийт 185,380.0 мянган төгрөгийн, Жавхлант суманд 10 ААНБ, 38 иргэн нийт 66,247.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хандив, тусламж үзүүлсэн байна.

“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ-ын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан 23 арга хэмжээнд 402,724.7 мянган төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж төлөвлөснөөс 29.3 хувийг баяр наадам, баярын хурал, концертын зардалд, 26.9 хувийг хүлээн авалт, зочид төлөөлөгчдийн зардалд, 24.8 хувийг хөрөнгө, бүтээн байгуулалтын зардалд, 6.8 хувийг тохижилт үйлчилгээний зардалд, 3.1 хувийг баримтат кино, дуу, клип, номны зардалд, 5.4 хувийг шагнал урамшууллын зардалд, 3.7 хувийг тэмцээн уралдаан, бусад зардал, ТББ-ийн үйл ажиллагааны зардалд зарцуулахаар тус тус төлөвлөсөн байна. / **Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй харах** /

“Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ-ын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан 51 арга хэмжээнд 230,088.6 мянган төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэж төлөвлөснөөс 42.5 хувийг баяр наадам, баярын хурал, концертын зардалд, 10.9 хувийг хүлээн авалт, зочид төлөөлөгчдийн зардалд, 27.5 хувийг хөрөнгө, бүтээн байгуулалтын зардалд, 39.1 хувийг тохижилт үйлчилгээний зардалд, 30.5 хувийг баримтат кино, дуу, клип, номны зардалд, 1.7 хувийг шагнал урамшууллын зардалд, 2.7 хувийг тэмцээн уралдаан, бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна. / **Хавсралт 2-оос дэлгэрэнгүй харах** /

1.3 Жавхлант, Сүхбаатар сумдууд нь биетээр орж ирсэн нийт 259,583.5 мянган төгрөгийн хөрөнгийн орлогыг санхүүгийн бүртгэл тайланд огт тусгаагүй байна.

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ нь 370,357.8 мянган төгрөгийн, “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ нь 134,806.6 мянган төгрөгийн зэрэг нийт 505,164.4 мянган төгрөгийн мөнгөн хандивын орлогыг бүртгэлд бүрэн тусгасан байна.

Харин Сүхбаатар суманд “Петровис” ХХК 30,000.0 мянган төгрөгөөр авто замын нөхөөс, “Алтан тариа” ХХК 34,000.0 мянган төгрөгөөр зам, замын тэмдэглэгээ, “Korea Standart” ХХК нь 50,000.0 мянган төгрөгөөр багш нарын болон төмөр замын 58 айлын орон сууцны дээврийн засвар, “Гацал хайрхан” ХХК нь 15,000.0 мянган төгрөгөөр тоглоомын талбай, иргэн Т.Батцэнгэл 54,000.0 мянган төгрөгөөр ногоон байгууламж,

“Дэээрэт” олон улсын энэрлийн байгууллагаас 2,380.0 мянган төгрөгөөр явган хүний 2 гүүр зэрэг нийт **185,380.0 мянган** төгрөгөөр бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэж, биет хандив, тусламж үзүүлснийг жилийн эцсийн санхүүгийн тайланд огт тусгаагүй байна.

Жавхлант сум нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас өгсөн 66,247.5 мянган төгрөгийн хөрөнгийн хандив тусламжийг бүртгээгүй байна.



/ Далангийн дэргэдэх явган хүний гүүр /



/ Орон сууцны дээврийн засвар /



/ Зам, замын тэмдэглэгээ /



/ Ногоон байгууламж /



/Замын нөхөөсийн ажил /



/ Жавхлант сум: тракторын хөшөө /

2. Ойн хандив, тусламжийн орлогоос Сүхбаатар сум 3,571.0 мянган төгрөг, Жавхлант сум 1,400.0 мянган төгрөг зэрэг нийт 4,971.0 мянган төгрөгийг төлөвлөгдөөгүй ажил гүйцэтгэх, бусдад хандив өгөх зэргээр зориулалт бусаар зарцуулсан байна.

2.1 Төлөвлөсөн арга хэмжээг “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ 96.0 хувиар, “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ 94.0 хувиар биелүүлсэн байна.

Сүхбаатар сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2017 оны 13 дугаар тогтоолоор батлагдсан ойн баярыг зохион байгуулах ажлын хэсгийн 2017 оны 6 сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцсэний дагуу “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ –ийн даргын баталсан Сүхбаатар сумын 80 жилийн ойн нэгдсэн төлөвлөгөөнд 23 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс 22 арга хэмжээг бүрэн / **Хавсралт 1-ээс харах** / , 1 арга хэмжээг дутуу хэрэгжүүлсэн байна. Үүнд:

Дутуу хэрэгжүүлсэн арга хэмжээ:

- "Умард хилийн харуул Сүхбаатар хот" номыг бичүүлэхээр зохиолч Т.Доржсүрэнтэй 2017.03.16-ы өдрийн №02 хамтран ажиллах гэрээ /гэрээний үнэ 5,000.0 мянган төгрөг, ном хүлээлгэн өгөх эцсийн хугацаа 2017.06.25/ байгуулж, урьдчилгаа санхүүжилт 2,500.0 мянган төгрөгийг олгосон боловч номыг өнөөдрийг хүртэл хүлээлгэж өгөөгүй байна.


Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 13 дугаар тогтоолоор баталсан сумын 40 жилийн ой зохион байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөгөөр 51 ажил, арга хэмжээ төлөвлөснөөс 48 арга хэмжээг бүрэн / **Хавсралт-2- оос харах** /хэрэгжүүлж, 3 арга хэмжээг огт хэрэгжүүлээгүй байна. Үүнд :

Хэрэгжүүлээгүй арга хэмжээ:


- Жавхлантын бахархал музей байгуулах 10,000.0 мянган төгрөгийн,
- Ахмадын шатрын тэмцээн 500.0 мянган төгрөгийн,
- Телевизэд зар, сурталчилгаа өгөх, сумын удирдлагууд телевизийн ярилцлагад орох 4,000.0 мянган төгрөгийн зэрэг болно.

ТББ-уудын төлөвлөсөн арга хэмжээний биелэлтийг графикаар илэрхийлбэл:

/график 1/



/график 2/




2.2 Хандив, тусламжийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээ гүйцэтгэх, бараа материалын тайлан гаргаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.

Сүхбаатар сумын 80 жилийн ойн арга хэмжээнд нийт 370,357.8 мянган төгрөгийн мөнгөн хандив, тусламжийн орлого төвлөрснөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 354,944.0 мянган төгрөг, 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 362,833.9 мянган төгрөгийг тус тус зарцуулж, харилцах дансанд 7,523.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сүхбаатар сумын хандив, тусламжийн орлогын зарцуулалтыг зардлын төрлөөр графикаар харуулбал:

/график 3, сая.төг/



“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ нь сумын түүхэн ой зохион байгуулахад цугласан хандивын 53.9 хувийг хөрөнгө, бүтээн байгуулалтын зардалд, 17.7 хувийг баяр наадам, баярын хурал, концерт зохион байгуулахад, 14.7 хувийг хүлээн авалт, зочид төлөөлөгчийн зардалд, 5.5 хувийг тохижилт, үйлчилгээний зардалд, 2.8 хувийг шагнал, урамшууллын зардалд, 2.7 хувийг баримтат кино, дуу, клип, номны зардалд, 1.0 хувийг бусад зардалд, 0.7 хувийг хандив, тусламжийн арга хэмжээнд, 0.5 хувийг тэмцээн, уралдааны зардалд, 0.5 хувийг ТББ-ийн үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулсан байна.

“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ нь хүлээн авалт, баяр ёслолын, баяр наадмын, зочид төлөөлөгчид хүлээн авах зардал, хандивлагч, зочид, төлөөлөгчдөд, айл өрхүүдэд олгох бэлэг дурсгалын, баярын хурал, концерт, үдшийн цэнгүүний мөн уралдаан тэмцээн, шагнал урамшууллын зардлуудыг төлөвлөснөөс бага зардлаар хийж


гүйцэтгэсэн бол дараах зардлуудыг төлөвлөснөөс нийт **12,811.8** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд:

- Баримтат кино, дуу, клип, номын зардлыг 2,323.5 мянган төгрөгөөр,
- Тохижилт үйлчилгээний зардлыг 2,698.3 мянган төгрөгөөр,
- Хөрөнгийн зардлыг 7,500.0 мянган төгрөгөөр,
- ТББ-ийн үйл ажиллагааны зардлыг 290.0 мянган төгрөгөөр зэрэг болно.

“Жавхлант сумын 40 жилийн ойн арга хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нийт 134,806.6 мянган төгрөгийн хандив, тусламжийн орлого төвлөрснөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 200,756.8 мянган төгрөгийг зарцуулж, 297.3 мянган төгрөгийг сумын орлогод төвлөрүүлснээр мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Жавхлант сумын хандив, тусламжийн орлогын зарцуулалтыг зардлын төрлөөр, графикаар харуулбал:

/график 4, сая.төг/



“Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ нь сумын 40 жилийн ой зохион байгуулахад цугласан хандивын 47.8 хувийг баяр наадам, баярын хурал, концерт зохион байгуулахад, 15.8 хувийг хүлээн авалт, зочид төлөөлөгчийн зардалд, 5.3 хувийг хөрөнгө, бүтээн байгуулалтын зардалд, 12.4 хувийг тохижилт, үйлчилгээний зардалд, 1.0 хувийг тэмцээн, уралдааны зардалд, 2.2 хувийг шагнал, урамшууллын зардалд, 13.7 хувийг баримтат кино, дуу, клип, номны зардалд, 1.8 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

“Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ нь нэр бүхий 20 арга хэмжээний зардлыг батлагдсан төсвөөс бага зардлаар хийж гүйцэтгэсэн бол дараах зардлуудыг төлөвлөснөөс **19,911.8** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Үүнд:

- *Жавхлант 40-н жилийн түүхэн ном бүтээх зардлыг 833.2 мянган төгрөгөөр,*
- *Жавхлант сумын түүхэн баримтат кино, СД хийх зардлыг 146.5 мянган төгрөгөөр,*
- *Ойн хүндэт тэмдгийг 500.0 мянган төгрөгөөр,*
- *Жавхлант түмний дуулал тоглолт, нээлт, гимнастикийн зардлыг 1,886.2 мянган төгрөгөөр,*
- *Хоггүй орчин, нийтийн хог цэвэрлэгээ хогийн цэг цэвэрлэх зардлыг 340.9 мянган төгрөгөөр,*
- *Гарын бэлэг бэлтгэх зардлыг 9,233.0 мянган төгрөгөөр,*
- *Бэлэгний уут бэлтгэх зардлыг 300.0 мянган төгрөгөөр,*
- *Миний нутаг сугалааг зохион байгуулах зардлыг 432.0 мянган төгрөгөөр,*
- *Урилга хэвлэх зардлыг 4,500.0 мянган төгрөгөөр,*
- *Наадмын зардлыг 824.4 мянган төгрөгөөр,*
- *Витаминжуулалтын зардал 400.0 мянган төгрөгөөр,*
- *Тэмцээн уралдааны зардлыг 508.0 мянган төгрөгөөр,*
- *Шатахууны зардлыг 7.6 мянган төгрөгөөр зэрэг болно.*

Сумдын ой тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагаатай холбоогүйгээр буюу төлөвлөгдөөгүй, бусдад өгсөн хандив тусламжийн үйл ажиллагаанд, зориулалт бусаар Сүхбаатар сум 2017 онд 1,500.0 мянган төгрөг, 2018 он гараад 2,071.0 мянган төгрөг зэрэг нийт 3,571.0 мянган төгрөгийг, Жавхлант сум 2017 онд 1,400.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Үүнд:

Сүхбаатар сум:

- *“Улаан ирвэс” клубын тамирчдын олон улсын тэмцээнд оролцох зардалд 1,000.0 мянган төгрөг,*
- *Спорт сургуулийн 10 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан 460.0 мянган төгрөгийн үнэ бүхий жижүүрийн тэк тавилга хандивласан,*
- *“Шинэ бадрах” ХХК-д жудо бөхийн дэвжээ авахад 500.0 мянган төгрөг хандивласан,*
- *1-р багийн иргэн н.Жаргалсайханы гэр шатсан учир 1,611.0 мянган төгрөгийн үнэ бүхий тусламжийн зүйлс зэрэг нийт 3,571.0 мянган төгрөгийн хандив тусламжийг олгосон байна.*

Жавхлант сум :

- *Боксын дэлхийн аваргын тэмцээнд оролцох хүүхдэд витаминь үнэ 400.0 мянган төгрөг,*
- *Хилийн цэргийн 0243-р ангид агт /адуу/ худалдан авахад 1,000.0 мянган төгрөг зэрэг болно.*

Аудитын явцад мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ :

- *Харилцагч байгууллагын нэхэмжлэх, зарлагын баримтгүй болон бусдаар ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу 19,384.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.*

- 2017 оны 7 сард “Сүлжээний урсгал” ХХК-д 5,000.0 мянган төгрөг шилжүүлсэн боловч ямар нэгэн худалдан авалт, ажил үйлчилгээ хийгдээгүй байхад ТББ-ийн санхүүгийн тайлан, балансад авлагаар тусгаагүй байна.
- 72,041.5 мянган төгрөгийн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Аудитын явцад “Сүлжээний урсгал” ХХК-д шилжүүлсэн 5,000.0 мянган төгрөг болон 2018 оны 3 сард Хаан банк, Голомт банкны харилцах данснаас бэлнээр гаргасан 2,481.0 мянган төгрөгийн кассын үлдэгдэл зэрэг нийт 7,481.0 мянган төгрөгийг Голомт банкин дахь харилцах дансанд төвлөрүүлэх гүйлгээг гүйцэтгүүлэв.

“Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ :

- Харилцагч байгууллагын нэхэмжлэх, зарлагын баримтгүй болон бусдаар ажил гүйцэтгүүлэхдээ гэрээ байгуулаагүй зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу 5,186.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн байна.
- 7,956.0 мянган төгрөгийн өртөг бүхий “Тариаланчдад зориулсан тракторын хөшөө” бүртгэл, тайланд тусгаагүй байна.

2.3 Сүхбаатар сумын ойг тэмдэглэн өнгөрүүлэх комиссын тайланг сумын ИТХ-аар хэлэлцэж, үнэлж, дүгнээгүй байна.

Сүхбаатар сумын 80 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өгсөн хандивын хүрээнд бий болсон **229,495.0** мянган төгрөгийн өртөг бүхий дараах хөрөнгүүдийг ТББ болон сумын ЗДТГ-ын хөрөнгийн бүртгэлд орлого авч, тайланд тусгаагүй байна. Үүнд:

- *Баримтат кино 6250,0 мянган төгрөг*
- *Дууны үг, ая, бичлэг, клип-3724,0 мянган төгрөг*
- *Зургийн аппарат-2550,0 мянган төгрөг*
- *Тоос сорогч-350,0 мянган төгрөг*
- *Дээл, плаж-349,0 мянган төгрөг*
- *Хурдан морины хүүхдийн номер-3142,0 мянган төгрөг*
- *Реклам шторк-250,0 мянган төгрөг*
- *Буудайн хөшөө-107500,0 мянган төгрөг*
- *Замын тэмдэглэгээ-34000,0*
- *Тоглоомын талбай-15000,0*
- *Ногоон байгууламж-54000,0*
- *Явган хүний гүүр-2380,0 мянган төгрөг зэрэг болно.*

Сумдын түүхт ойн арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр байгуулагдсан төрийн бус байгууллагууд нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламжийн хүрээнд бий болсон хөрөнгийг санхүүгийн бүртгэл тайланд тусгаагүй, харьяалах орон нутгийн захиргааны байгууллагуудад шилжүүлэн өгөх ажлыг хэрэгжүүлээгүй байгаа нь хөрөнгө шамшигдах, нийтийн эзэмшлийн зам, талбай, хөшөө дурсгал зэрэг үндсэн хөрөнгө эзэнгүйдэх, эвдрэх эрсдэлийг бий болгож байна.

Сүхбаатар сумын 80 жилийн үйл ажиллагаанд зориулан төвлөрүүлсэн хандив, тусламжийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, гүйцэтгэл болон “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд сум, орон нутгийн байгууллагууд, албан тушаалтнуудын зүгээс хяналт хийгдээгүй, санхүүгийн бүртгэл, тайланг албан ёсоор баталгаажуулаагүй байна. Тус сумын “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” төрийн бус байгууллага нь хандив, тусламжийн орлого, зарлагын баримт, материалыг архивлаж, үдэж, цэгцлээгүй, бэлэн мөнгөний орлого зарлагын тайлан мэдээ гаргаагүй байсныг аудитын явцад нөхөн хийлгүүлсэн болно.

Жавхлант сумын Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Сумын 40 жилийн ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих тухай" А/73 дугаар захирамжаар “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ-ын дансанд төвлөрсөн хандивын орлого, зарлагын байдалд хяналт тавьж, тогтмол мэдээллээр ханган ажиллахыг Санхүүгийн албаны дарга Б.Эрдэнэцэцэгт даалгасан боловч тусгайлан хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд хандивын орлого, зардлын тайланг эмх цэгцтэй үдэж, архивын нэгж болгон хадгалсан байна.

Сүхбаатар сумын “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө”, Жавхлант сумын “Жавхлантын хөгжлийн төлөө” төрийн бус байгууллагууд нь хандив, тусламжийн орлого бүрдүүлэлт, зарцуулалт, түүхт ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд хийсэн ажлын тайлан, танилцуулгыг бэлтгэж, ерөнхий дүнгээр Сүхбаатарын мэдээ, Жавхлантын мэдээ зэрэг сонингуудаар нийтэд мэдээлсэн бөгөөд Жавхлант сумын ИТХ-ын 2017 оны 18 дугаар тогтоолоор ойн баяр наадмыг зохион байгуулах комиссын тайланг авч хэлэлцээд “**хангалттай**” гэж дүгнэсэн бол Сүхбаатар сумын тайлан, дүнг албан ёсоор үнэлж, дүгнээгүй байна.

ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧИЛ

Жавхлант, Сүхбаатар, Хушаат сумдын ойн хандивын зарцуулалт, үр дүнд хийсэн аудиттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Сүхбаатар сум:

- ❖ “Петровис” ХХК-ийн 30,000.0 мянган төгрөгөөр авто замын нөхөөс хийж гүйцэтгэсэн биет бус хандивыг үр дүнгийн тайланд тусгаагүй,
- ❖ "Умард хилийн харуул Сүхбаатар хот" ном бичүүлэхээр байгуулсан гэрээний дагуу 2,500.0 мянган төгрөгийг иргэн Т.Доржсүрэнд олгосон боловч гэрээт хугацаанд хүлээж аваагүй, авлагаар бүртгээгүй,
- ❖ Ойн арга хэмжээнд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс 3,571.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, бусдад хандив өгсөн,
- ❖ Анхан шатны баримтын бүрдэл дутуу 19,384.8 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн,
- ❖ 72,041.5 мянган төгрөгийн бараа материалын хөдлөл, өөрчлөлтийг жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаагүй,

- ❖ Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өгсөн хандиваар бий болсон 229,495.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгүүдийг бүртгэл, тайланд орлого авч, тусгаагүй зэрэг нийт **356,992.3** мянган төгрөгийн зөрчил илэрч, албан шаардлага бичигдэв.

Жавхлант сум:

- ❖ Хөрөнгийн хандив, тусламжийн орлого 66,247.5 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй,
- ❖ Ойн арга хэмжээнд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс 1,400.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, бусдад хандив өгсөн,
- ❖ Анхан шатны баримтын бүрдэл дутуу 5,186.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн,
- ❖ Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өгсөн хандиваар бий болсон **7,956.0** мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгүүдийг бүртгэл, тайланд орлого авч, тусгаагүй зэрэг нийт **80,790.0** мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага бичигдэв.

Аудитын дүнгээр / 2 сумын дүнгээр / **нийт 437,782.3** мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч, **албан шаардлага** бичигдлээ.

ТАЙЛАНГИЙН ТӨСЛИЙН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ-ийн даргын 2018 оны 06 сарын 29-ний өдрийн 0/26 албан бичгээр тайлангийн төсөлд санал, тайлбар ирүүлснийг хүлээн авч холбогдох өөрчлөлтийг тайланд тусгаж дараах байдлаар өөрчлөлт оруулав.

№	Санал авахаар хүргүүлсэн төсөлд тусгагдсан асуудлууд	“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ-аас ирүүлсэн санал	Саналыг хүлээн авч, тайлангийн төсөлд өөрчлөлт оруулсан асуудлууд
1	Ойн арга хэмжээнд төвлөрсөн мөнгөн хөрөнгөөс 1,392.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, өвлийн морин уралдааны хүүхдийн номерын төлбөр төлсөн.	2017 оны 07 дугаар сарын 30-нд болсон хурдан морьны уралдааны номерийн үнийг нөхөн шилжүүлсэн болно.	Саналыг хүлээн авч зөрчлийн дүнгээс хасав.
2	Хаан, Голомт, Төрийн банкны харилцах дансны нийт үлдэгдэл 7,523.9 мянган төгрөгийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх	Сүхбаатар суманд хийгдсэн “Атарчдын хөшөө”-г хийлгэхээр “Таванхан уул” ХХК-тай 120,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулсан боловч тус компани руу 107,500.0 мянган төгрөг шилжүүлсэн бөгөөд үлдэгдэл мөнгө болох 12,500.0 мянган төгрөгийг шилжүүлэх шаардлагатай байна. Иймд манай байгууллагын дансны үлдэгдэл болох 7,523.9 мянган төгрөгийг	Саналыг хүлээн авч зөрчлийн дүнгээс хассан ба гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр тооцоог эцэслэж, ойн үйл ажиллагаатай холбогдуулан арилжааны банкуудад нээсэн харилцах

	“Таванхан уул” ХХК руу шилжүүлэх саналтай байна.	дансыг хаах зөвлөмж болгон зассан.
--	--	------------------------------------

“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ-аас ирүүлсэн санал

**СҮХБААТАР СУМЫН
ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ТББ**

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан эрэг II баг
Утас: 99093870

2018.05.29 № 2/а
танай _____ -ны № _____ -т

Тайлбар гаргах тухай

Сүхбаатар сумын 80 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд хийгдсэн ажил арга хэмжээнд танай байгууллагаас шалгасан шалгалтын явцад илэрсэн 1.392.000 төгрөгний хурдан морины уралдаанч хүүхдийн номерийн төлбөр нь 2017 оны 07 дугаар сарын 30-нд болсон хурдан морины уралдааны номерийн үнийг нөхөн шилжүүлсэн болно.

Сүхбаатар сумын Хөгжлийн төлөө ТББ-ын дансанд 7.481.000 төгрөгний үлдэгдэлтэй байгаа ба Сүхбаатар суманд хийгдсэн Атарчдын хөшөөг хийлгэхээр Таванхан уул ХХК-тай 120.000.000 төгрөгний гэрээ байгуулсан боловч тус компанируу 107.500.000 төгрөг шилжүүлсэн бөгөөд үлдэгдэл мөнгө болох 12.500.000 төгрөгийг шилжүүлэх шаардлагатай байгаа. Иймд манай байгууллага өөрийн дансны үлдэгдэл болох 7.481.000 төгрөгийг Таванхан уул ХХК-руу шилжүүлэх саналтай байна.

ЗАХИРАЛ



Б.СУУРЬБАТ

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ❖ Сүхбаатар сумын ойг тэмдэглэх ажлын хэсгийн хурлын тэмдэглэл, ажлын төлөвлөгөө, санхүүгийн төсөв зэрэг нь холбогдох албан тушаалтны гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажаагүй, албан бичиг хэрэг хөтлөлтийн стандарт, шаардлагыг хангаагүй байна.
- ❖ Жавхлант сум нь Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолын 3.3 дахь “ *Орон нутгийн байгууллагын 50 болон түүнээс дээшхи 10 жилийн давтамжтай тэгш ойг тэмдэглэх асуудлыг аймаг, нийслэлийн ИТХ шийдвэрлэнэ* ” гэсэн заалтыг зөрчин, аймгийн ИТХ-ын шийдвэр гараагүй байхад сум байгуулагдсаны 40 жилийн ойг тэмдэглэсэн байна.
- ❖ “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ -ын даргаар сумын Засаг даргын орлогч Ж.Хүрэлбаатар ажиллаж, ойн арга хэмжээтэй холбоотой хөрөнгийг зарцуулсан нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.
- ❖ Ойн арга хэмжээний хандив, тусламжийн орлогын төлөвлөгөө Сүхбаатар сумын хувьд 138,0 хувийн биелэлттэй, Жавхлант сумын хувьд 87.4 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.
- ❖ Сүхбаатар сум нийт 185,380.0 мянган төгрөгийн хөрөнгийн, Жавхлант сум 74,203.5 мянган төгрөгийн бараа материалын хандив, тусламжийн орлогыг тус тус бүртгэл, тайланд тусгаагүй байна .
- ❖ Төлөвлөсөн арга хэмжээг “Сүхбаатар сумын хөгжлийн төлөө” ТББ 96.0 хувиар, “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ 94.0 хувиар биелүүлсэн байна.
- ❖ Ойг тэмдэглэх ажлын хүрээнд бий болсон 229,495.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Сүхбаатар сум, 7,956.0 мянган төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Жавхлант сум орлого авч, бүртгэл тайланд тусгаагүй байна.
- ❖ Ойн хандив, тусламжийн орлогоос Сүхбаатар сум 3,571.0 мянган төгрөг, Жавхлант сум 1,400.0 мянган төгрөг зэрэг нийт 4,971.0 мянган төгрөгийг төлөвлөгдөөгүй ажил гүйцэтгэх, бусдад хандив өгөх зэргээр зориулалт бусаар зарцуулсан байна
- ❖ Сүхбаатар, Жавхлант сумдын ойн арга хэмжээнд төвлөрсөн хандив, тусламжийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод хяналт, шалгалт хийгдээгүй байна.
- ❖ Сүхбаатар сумын ойг тэмдэглэн өнгөрүүлэх комиссын тайланг сумын ИТХ-аар хэлэлцүүлж, дүгнүүлээгүй бол Жавхлант сумын ойн арга хэмжээний тайланг сумын ИТХ-аар хэлэлцэж, “ хангалттай” гэж дүгнэсэн байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Сүхбаатар, Жавхлант сумдын ИТХ болон Засаг дарга, ЗДТГ-ын дарга нарт:

- ❖ Орон нутгийн байгууллагын түүхэн, тэмдэглэлт ойг тэмдэглэх, шийдвэр гаргахдаа Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах дурсгалыг нь мөнхжүүлэх журам” –ыг мөрдөж ажиллах.
- ❖ Ойн хандив тусламжийн орлого төвлөрүүлэх зарцуулахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай болон холбогдох бусад хууль, эрхийн актыг мөрдлөг болгох.
- ❖ Хандив, тусламжийн хүрээнд төвлөрсөн мөнгөн болон биет хөрөнгийн орлого, барьж байгуулсан, бий болсон хөрөнгүүдийг холбогдох байгууллагуудын бүртгэл, тайланд бүрэн хэмжээгээр тусгах.
- ❖ Ойн хандивын орлого бүрдүүлэлт, зарцуулалтад сум, орон нутгийн удирдлагын зүгээс хяналт, шалгалт хийж, тайлан мэдээллийг сумын ИТХ, ард иргэдэд тайлагнаж, үнэлүүлж, дүгнүүлэх.
- ❖ Ойн хандиваар бий болсон биет хөрөнгийг ИТХ-аар шийдвэр гаргуулсны үндсэн дээр холбогдох байгууллагуудын хөрөнгөд бүртгэж, хүлээн авах.
- ❖ "Умард хилийн харуул Сүхбаатар хот" номын эхийг гэрээний дагуу бүрэн дуусгаж, хүлээн авах.

“Сүхбаатар сумын хөгжлийн төлөө”, “Жавхлант сумын хөгжлийн төлөө” ТББ-уудын дарга, нягтлан бодогч нарт:

- ❖ Ойн хандиваар хийгдсэн бүтээн байгуулалтын ажлууд, үүсэн бий болсон хөрөнгийг сум орон нутгийн холбогдох байгууллагуудад шилжүүлэн өгч, бүртгэл тайланд тусгуулах,
- ❖ Гэрээний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөр тооцоог эцэслэж, ойн үйл ажиллагаатай холбогдуулан арилжааны банкуудад нээсэн харилцах дансыг хаах,
- ❖ Бүртгэл, санхүүгийн анхан шатны баримтуудыг үдэж цэгцлэн, архивын нэгж болгон сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

Ц.УРТНАСАН

А.ДАШБАТ

**СҮХБААТАР СУМ БАЙГУУЛАГДСАНЫ 80-Н ЖИЛИЙН ОЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ**

№	Ойн хандиваар хийгдэх ажил	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
		/мян.төг/			
1	Хандивлагчдын болон нутгийн зөвлөл, 80 жилийн хүндэтгэлийн хүлээн авалтууд /Хүндэтгэлийн уулзалт 5 удаа зохион байгуулна./	35,034.6	35,008.7	25.9	
2	Баримтат кино, дуу, ном /Сүхбаатар хотын тухай дуу 2 клип, баримтат кино, 2, 15 минутын танилцуулга, 30 секундын шторк/	12,474.0	14,797.5	(2,323.5)	"Умарт хилийн харуул Сүхбаатар хот" номыг бичүүлэх гэрээний хугацаа дууссан боловч номыг өнөөдрийг хүртэл хугацаанд бүрэн дуусгаагүй байна.
3	Хурдан морьны уралдааны салбар хорооны зардал/нэмнээ, унаач хүүхдүүдийн гарын бэлэг, морьны гарааны төхөөрөмжинд ажилласан хүмүүсийн цалин, шатахуун/	12,644.3	11,010.4	1,633.9	
4	Бөхийн салбар хорооны зардал /Бөхийн бай, хөлийн цэц, засуул, даваа, оноолтын мөнгө/	19,985.4	19,985.4	-	
5	Сурын холбооны зардал /Зурхай засах, шүүгчийн хөлс, бусад/	3,900.0	3,900.0	-	
6	УАЗ-469 бартаар замын уралдаан, дрифтийн уралдаан /шагнал/	3,000.0	3,000.0	-	
7	Шагайн харвааны зардал /Шагайн харвааны бай шагнал, бэлтгэл ажлын зардал, бусад зардал/	4,500.0	4,000.0	500.0	
8	Төрийн ёслол хүндэтгэл, зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулсны зардал /Номадс, Сэлэнгэ, Номуун, Хилийн 0243-р ангийн номтын амралт, 1-р сургууль, Спорт сургуулиудад зочид төлөөлөгчдийг байрлуулах/	15,530.0	7,505.4	8,024.6	
9	Баярын хурал, концерт, баяр наадмын нээлтийн үйл ажиллагаа /Наадмын нээлт, баярын хурал, концертийн үйл ажиллагаанд 420 хүний бэлтгэл ажил болон хоолны зардал/	36,500.2	17,813.8	18,686.4	

10	80 жилийн ойн баярыг тохиолдуулсан айл өрхүүдэд тараасан өрхийн бэлэг /5864 айл өрхөд олгох/	17,141.0	7,870.0	9,271.0	
11	Хандивлагч болон зочид төлөөлөгчдийн гарын бэлэг /Мөнгөн аяга 140ш, гуулин аяга 270ш/	22,741.1	21,190.8	1,550.3	
12	Шагнал урамшуулалд Сумын хүндэт 3 иргэнд, урамшуулал, жуух бичиг хэвлүүлэх, спортын тэмцээний 80 жилийн логотой медаль/	10,359.8	4,546.0	5,813.8	
13	80 жилийн ойн хүндэт медаль /Сүхбаатар сумын өндөр настан болон ахмад ажилтан/	11,500.0	11,500.0	-	
14	Баяр наадмын үйл ажиллагаатай холбоотой цагдаагийн хамгаалалт /3 хоногийн шатахуун, хоол, хамгаалалтын зардал/	3,269.0	3,269.0	-	
15	Тохижилт үйлчилгээний зардал /Зар сурталчилгааны самбар дээр хулдаасан хэвлэл байрлуулсан/	27,226.4	29,924.7	(2,698.3)	
16	Буудайн хөшөөний зардал /Гурвалжингийн уулзвар дээрх хөшөө/	100,000.0	107,500.0	(7,500.0)	
17	Баярын үйлчилгээний зардал /Наадмын төв талбайн үзэгчид болон төв асар, хүндэтгэлийн гэрүүдийн зардал/	17,703.9	8,399.8	9,304.1	
18	Шатахууны зардалд /Баяр наадмын бэлтгэл ажил Улаанбаатар, Дархан хотуудын нутгийн зөвлөлийн уулзалт, баярын өмнөх хог тээвэрлэлтийн шатахуун, баярын өдрүүдийн үйлчилгээний шатахуун/	2,245.0	2,191.4	53.6	
19	Үдшийн цэнгүүн /Баяр наадмын 3 удаагийн үдшийн цэнгүүн/	36,510.0	36,500.0	10.0	
20	Ёслолын буудлага /Баярын нээлт, хаалтын үйл ажиллагааны ёслолын буудлага/	4,000.0	4,000.0	-	
21	"Сүхбаатар хотын хөгжлийн төлөө" НҮТББ-ийн зардал /Үйл ажиллагааны зардал/	2,410.0	2,700.0	(290.0)	
22	Зургийн аппарат /Мэдээлэл сурталчилгааны техник хэрэгслийн зардал/	2,550.0	2,550.0	-	
23	Спортын тэмцээн уралдааны зардал /Баяр наадмын спорт тэмцээн уралдааны зардал/	1,500.0	100.0	1,400.0	

24	Төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал /Хандив, тусламжийн арга хэмжээ/		3,571.0	(3,571.0)	
ДҮН		402,724.7	548,213.9	39,890.8	

/Хавсралт 2/

ЖАВХЛАНТ СУМ БАЙГУУЛАГДСАНЫ 80-Н ЖИЛИЙН ОЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ, БИЕЛЭЛТ

№	Ойн хандиваар хийгдэх ажил	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Тайлбар
		/мян.төг/			
1	Жавхлант 40-н жилийн түүхэн ном бүтээх	11,500.0	12,333.2	(833.2)	
2	Жавхлант сумын түүхэн баримтат кино, сиди	15,000.0	15,146.5	(146.5)	
3	Жавхлантын бахархал Музей байгуулах	10,000.0	-	10,000.0	Хэрэгжээгүй
4	Шагай сурын харвааны хэрэгсэл	3,000.0	1,400.0	1,600.0	
5	Ойн хүндэт тэмдэг	4,000.0	4,500.0	(500.0)	
6	Жавхлант түмний дуулал тоглолт , нээлт гимнастик	12,625.3	14,511.4	(1,886.2)	
7	Жавхлантын үдэш шоу арга хэмжээний зардал	15,850.0	15,850.0	-	
8	'Манай гудамж-миний гэр' аяныг зохион байгуулж хаягжуулалт хийх	3,000.0	1,186.0	1,814.0	
9	"Жавхлант-40 цогцолбор" барьж тохижуулах	10,000.0	1,000.0	9,000.0	
10	Нийтийн эзэмшлийн ОО-ыг засварлах, хогийн сав байрлуулах	3,500.0	2,571.7	928.3	
11	Нийтийн эзэмшлийн хашаа, талбайг засварлаж будах	1,000.0	936.7	63.4	
12	Төв замын уулзварын хөшөөг засварлаж, тохижилт хийх	1,265.1	1,000.0	265.1	
13	2 багийн хүүхдийн тоглоомын талбайнуудыг засаж тохижуулах	1,500.0	521.5	978.5	
14	ААНБ-н өнгө үзэмж нэмэх	-	-	-	
15	Тракторын хөшөө босгох	15,000.0	7,456.0	7,544.0	
16	Ахмадын шатрын тэмцээн	500.0	-	500.0	Хэрэгжээгүй
17	Хоггүй орчин нийтийн хог цэвэрлэгээ хогийн цэг цэвэрлэх	1,740.4	2,081.2	(340.9)	
18	ЗДТГазар/шилэн хорго-1760920, дотор, гадна завсар-2673500 төг	4,434.4	4,434.4	-	
19	Соёлын төвийн засвар үйлчилгээ	8,153.0	8,151.9	1.1	

20	26-р цэцэрлэгийн засвар үйлчилгээ	2,820.0	1,600.0	1,220.0	
21	ЕБСургууль unimat технологийн кабинет	2,500.0	2,500.0	-	
22	ЭМТөв гадна хашааны засвар	1,724.1	1,724.1	-	
23	Телевизид зар, сурталчилгаа өгөх, сумын удирдлагууд телевизийн ярилцлагад орох	4,000.0	-	4,000.0	Хэрэгжээгүй
24	Гарын бэлэг бэлтгэх /нэр төрлийг сонго/	5,000.0	14,233.0	(9,233.0)	
25	Баяр наадмын үйл ажиллагааг бичих нэвтрүүлэх	2,300.0	1,000.0	1,300.0	
26	Жавхлант бэлэгний уут бэлтгэх	1,200.0	1,500.0	(300.0)	
27	Миний нутаг сугалааг зохион байгуулах	2,700.0	3,132.0	(432.0)	
28	Урилга хэвлэх /1000ш*2000/	2,000.0	6,500.0	(4,500.0)	
29	Азарга	5,700.0	5,350.0	350.0	
	Их нас	5,700.0	5,900.0	(200.0)	
	Соёолон	5,700.0	5,740.0	(40.0)	
	Хязаалан	4,850.0	4,750.0	100.0	
	Шүдлэн	4,850.0	4,900.0	(50.0)	
	Даага	5,150.0	5,350.0	(200.0)	
30	Эрлийз морьдын уралдаан зохион байгуулах/ 3 насны/	13,750.0	8,840.0	4,910.0	
31	Морины номер	500.0	500.0	-	
32	Үндэсний бөхийн барилдаан зохион байгуулах /128/	5,730.0	4,458.8	1,271.2	
33	Хүүхдийн барилдаан	140.0	159.0	(19.0)	
34	Шигшээ барилдаан	560.0	589.0	(29.0)	
35	Урамшуулал / бөхийн/	300.0	300.0	-	
36	Нум сум харвааны шагнал	1,005.0	1,057.5	(52.5)	
37	Шагайн харваа	990.0	1,224.0	(234.0)	
38	Гар бөмбөгийн тэмцээний шагнал	1,378.0	1,636.0	(258.0)	
39	Хүүхдүүдийн дунд зохион байгуулах тэмцээний шагнал	188.0	46.0	142.0	
	Дээлтэй монгол тэмцээний шагнал	-	250.0	(250.0)	
40	Бөхийн засуул, цоллоочийн хувцас	1,200.0	1,200.0	-	

41	Аймаг сумын нутгийн бөхчүүдийн бэлтгэл сургуулалтанд дэмжлэг үзүүлэх	2,000.0	1,000.0	1,000.0	
42	Баяр наадмын нээлтийн жагсаалт /парад/ лого шаар	2,000.0	1,812.0	188.0	
43	Хандивын уулзалт хийх зардал	4,591.9	4,591.9	-	
44	Хүлээн авалтын зардал	9,293.5	7,375.4	1,918.1	
45	Хүлээн авалтын аяга, таваг поркат	1,000.0	1,000.0	-	
46	Гэр асрын хүндэтгэлийн зардал	4,000.0	4,000.0	-	
47	Бэлтгэл ажлын шатахууны зардал	1,500.0	1,507.6	(7.6)	
48	Хөтөлбөр, анонс, хулдаасан самбар хийх	300.0	300.0	-	
49	Намираа, хэл, оёх	100.0	100.0	-	
50	Гэрийн дотуур, гадуур бүрээс, бүслүүр, татлага	300.0	150.0	150.0	
51	Хурдан морь зохион байгуулах зардал	1,000.0	1,000.0	-	Төлөвлөгдөөгүй бөгөөд бусдад өгсөн хандив
	Витаминжуулалтын зардал	-	400.0	400.0	Төлөвлөгдөөгүй бөгөөд бусдад өгсөн хандив
ДҮН		230,088.6	200,756.8	29,331.8	